



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/108

Мандалговь

“Сайжруулсан ариун цэврийн байгууламж /Сайнцагаан сум”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сайжруулсан ариун цэврийн байгууламж /Сайнцагаан сум”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Түмэндэлгэр (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ю.Отгондэлгэр (Иргэний төлөөлөл)  
Г.Оюунтунгалаг (Аймгийн Засаг даргын Тамгын газар Хэвлэл мэдээллийн ажилтан)

Э.Дүүрэнжаргал (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Түмэндэлгэр)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай хобогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



488211178